



МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

2020 он 04 дугаар
сарын 16-ны өдөр

Дугаар 197/985

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
З.НАРАНТУЯА ТАНАА

Асуулгын хариу хүргүүлэх тухай

Шинэ коронавирусийн эдийн засагт үзүүлэх нөлөөлөл болон учрах эрсдэлийг бууруулах хүрээнд авч хэрэгжүүлж байгаа ажлын талаар Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан асуулгын хариуг Танд хүргүүлж байна.


Асуулгатай холбоотой асуудлаар Монголбанкнаас ирүүлсэн мэдээллийг хавсаргав.

Хүлээн авч, танилцана уу.

Хавсралт: 31 хуудастай.

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга



 J. ОЮУН-ЭРДЭНЭ

2056150

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН З.НАРАНТУЯАГААС МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДАД ТАВЬСАН АСУУЛГЫН ХАРИУ

Асуулга 1. Эдийн засаг, нийгэм, санхүүгийн салбарт үзүүлж болзошгүй нөлөөллийн тооцоолол

2002 онд SARS-ын тархалтын үед 774 хүн нас барсан бөгөөд вирусийн тархалт буурч, шинээр тохиолдол бүртгэгдэхгүй болсны дараа үеэс БНХАУ-ын хөрөнгийн зах зээл сэргэж эхэлсэн. Тухайн үед өмнөд хөршийн эдийн засгийн өсөлт 1 нэгж хувь удааширсан бол энэ удаа БНХАУ-ын эдийн засгийн өсөлт 4 нэгж хувиар саарах эрсдэл үүссэн төдийгүй дэлхийн эдийн засаг уналттай гарах төлөвтэй байна¹. ОУВС-гаас 2020 онд дэлхийн эдийн засгийн өсөлт хамгийн багадаа 2008 оны санхүүгийн хямралын үеийнхтэй дүйцэхүйц хэмжээгээр унах бөгөөд 2021 онд огцом сэргэнэ гэж үзэж байгаагаа мэдэгдлээ². Дэлхийн эдийн засаг ийнхүү саарч, дэлхий даяар хөл хөдөлгөөн татарч, тээвэр логистикийн үйл ажиллагаа доголдсон нь манай улсын эдийн засагт мэдэгдэхүйц нөлөөлж байна.

Сангийн яам коронавирусийн эдийн засагт үзүүлэх нөлөөллийг үнэлж тооцох ажлын хэсгийг 2020 оны 2 дугаар сард байгуулж, өдөр тутам хуралдан, шаардлагатай арга хэмжээг шуурхай авч ажиллаж байна. COVID-19 вирусийн дэгдэлтийн нөлөөгөөр Монгол Улсын 1) Экспортын орлого буурах, 2) БНХАУ-аас орц, түүхий эдээ авдаг дотоодын үйлдвэрлэл доголдох, 3) Дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнэ буурах, 4) Иргэдийн болгоомжлол, хүлээлт өөрчлөгдөж, худалдан авалт, эрэлт саарах зэрэг сөрөг үр дагавар гарах эрсдэлт нөхцөл үүссэн. Монгол Улсын үйлдвэрлэлийн түвшин 2017 оноос сэргэж, 2019 онд потенциал ДНБ-ий орчимд хүрч, бодит дотоодын нийт бүтээгдэхүүн 5.1 хувиар өссөн. Гэвч COVID-19 вирусийн дэгдэлтийн нөлөөгөөр бизнесийн үйл ажиллагаа саарч манай төсвийн нийт орлого төлөвлөсөн хэмжээнээс дутаж, эдийн засгийн өсөлт огцом саарч байна. Монгол Улсын эдийн засаг энэ оны эхний улиралд уналттай гарахаар байгаа тул бидний тооцоогоор 2020 онд эдийн засгийн өсөлт 1.1 хувь байх төлөвтэй байна. Дэлхийн банк Монгол Улсын эдийн засаг 2020 онд 2.4 хувиар өснө гэж таамаглаж байгаа бол АХБ 2.1 хувиар өснө гэж үзжээ. Эдийн засаг, бизнесийн идэвхжил саарч байгаагаас иргэд, ААН-ийн үйл ажиллагааны орлого буурч, зээл төлөлт доголдож эхлээд байна. Тухайлбал, хадгаламжийн байгууллагуудын хугацаа хэтэрсэн зээл 2020 оны 2 дугаар сард 1030.3 тэрбумд хүрч оны эхнээс 206.3 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд цаашид чанаргүй зээлийн хэмжээ өсөх эрсдэл нэмэгдээд байна.

Асуулга 2. Төсвийн орлого, зарлага, санхүүжилт, төлбөрийн тэнцэл, валютын нөөц, инфляци, ханш, санхүүгийн тогтвортой байдал, хөдөлмөрийн зах зээлд үзүүлэх сөрөг үр дагавар, дүгнэлт

Төсвийн орлого. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны нийт орлогыг 12.9 тэрбум төгрөг байхаар баталсан. COVID-19 вирусийн дэгдэлтийн нөлөөгөөр гадаад худалдааны эргэлт агшиж, экспорт, импортоос хамааралтай төсвийн орлого ихээр

¹ Дэлхийн эдийн засгийн өсөлт 2020 онд -0.2 хувь, БНХАУ-ын эдийн засгийн өсөлт 1.4 хувь байна гэж Bloomberg economics төсөөлжээ.

² <https://www.bloomberg.com/news/articles/2020-03-23/imf-sees-recession-at-least-as-bad-as-global-financial-crisis?srnd=economics-yp>

буурч байгаа тул улсын нэгдсэн төсвийн орлого энэ оны эхний улирлын байдлаар төлөвлөсөн хэмжээнээс 97.8 тэрбум төгрөгөөр буураад байна.

Зарлага санхүүжилт. Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан Засгийн газрын 2020 оны 78 дугаар тогтоол батлагдсан бөгөөд уг тогтоолын дагуу төсвийн орлогын бүрдэлттэй уялдуулан төсвийн захирагч нарын төсвийг хэмнэлтийн горимд шилжүүлж, цалин, тэтгэвэр бусад зарлагыг эрэмбэ тогтоож санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайдад даалгасан болно. Иймд зарлагын санхүүжилтийг эрэмбэлж, цалин, тэтгэвэр болон коронавирус халдвар (COVID-19)-ын цар тахлын онцгой нөхцөл байдалтай холбоотой зардлыг тэргүүн ээлжид санхүүжүүлж, бусад тэвчиж болох зардлыг эрэмбэ тогтоон санхүүжүүлж байна.

Төлбөрийн тэнцэл. Төлбөрийн тэнцэл 2019 оны 2 дугаар сарын байдлаар 182.6 сая ам.долларын ашигтай гарч байсан бол 2020 оны 2 дугаар сарын байдлаар 82.8 сая ам.долларын алдагдалтай гарлаа. Монгол Улсын экспортын орлого 2020 оны 2 дугаар сарын байдлаар 770.7 сая доллар буюу өмнөх оны мөн үеэс 29.5 хувиар буурсан байна. Үүнд чулуун нүүрсний экспорт 228.8 сая доллар болж өмнөх оны мөн үеэс 30.3 хувь буурсан, мөн зэсийн баяжмалын экспорт 219.1 сая доллар болж өмнөх оны мөн үеэс 16.2 хувь буурсан байна. COVID-19 вирусийн дэгдэлтийн нөлөөгөөр экспортын орлого ийнхүү буурч байгаа нь бараа ба үйлчилгээний тэнцлийн алдагдал 311.4 сая ам.долларт хүрч, төлбөрийн тэнцэл алдагдалтай гарахад голлон нөлөөлсөн байна.

Гадаад валютын албан нөөц. Гадаад валютын албан нөөцийн хэмжээ 2020 оны 2 дугаар сарын эцэст 4,371.3 сая ам.долларт хүрсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 20.7 хувиар, оны эхнээс 0.52 хувиар тус тус өссөн байна.

Инфляци, валютын ханш. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2020 оны 2 дугаар сард улсын хэмжээнд өмнөх сараас 1.2 хувь, өмнөх оны эцсээс 2.1 хувь, өмнөх оны мөн үеэс 6.4 хувиар өссөн байна. COVID-19 вирусийн тархалтын нөлөөгөөр 2020 онд эдийн засгийн өсөлт буурч байгаа нь эрэлтээс үүдэлтэй инфляцийн дарамтыг зөөлрүүлж байна. Иймд инфляцийн түвшин 2020 онд Төв банкны зорилтот түвшин болох 8 хувиас бага түвшинд байхаар байна. 2020 оны 2 дугаар сарын байдлаар төгрөгийн ханш суларсан боловч өмнөх онуудын 1, 2 дугаар сартай харьцуулахад ханшийн уналтын хувь бага байна.

Санхүүгийн тогтвортой байдал. Зээлийн өрийн үлдэгдлийн хэмжээ 2020 оны 2 дугаар сарын эцэст 17.3 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны эцсээс 4.1 хувиар буурсан байна. Хэдийгээр зээлийн өрийн үлдэгдлийн хэмжээ буурч байгаа ч чанаргүй зээлийн хэмжээ өмнөх оны эцсээс 16.8 тэрбум төгрөгөөр өсөж, 1,842.0 тэрбум төгрөгт хүрсэн байна. Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хэмжээ 10.6 хувь байна. Хадгаламжийн байгууллагуудын хугацаа хэтэрсэн зээл 2019 оны 12 дугаар сарын байдлаар 824 тэрбум байсан бол 2020 оны 2 дугаар сард 1030.3 тэрбумд хүрч 206.3 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь иргэд, ААН-ийн үйл ажиллагааны орлого буурч байгааг илтгэх бөгөөд цаашид чанаргүй зээл өсөх эрсдэл байгааг харуулж байна.

Хөдөлмөрийн зах зээл. Түүхий эдийн үнэ, эрэлт буурснаар Монгол Улсын экспорт буурч, гадаад худалдаа агшиж байна. Үүний үр дүнд төсвийн орлого, өрхийн хэрэглээ буурч, нийт эрэлт саарч байгаа нь хөдөлмөр, капиталын эрэлтийг бууруулж

байна. Тухайлбал, ажилгүйдлийн даатгалын сангийн зарлага 2020 оны эхний 2 сард өмнөх оны мөн үетэй харьцуулахад 41.8 хувиар өсөөд байгаа бол ажилгүйдлийн даатгалын сангийн орлого 2020 оны 2 дугаар сард өмнөх оны мөн үетэй харьцуулахад 15.8 хувиар буураад байна. Ажлын байр цөөрч, ажилгүйдлийн даатгалын сангаас тэтгэмж авах иргэдийн тоо өсөж байгааг харуулж байна. COVID-19 вирусийн нөлөөгөөр цаашид ажилгүйдэл өсөж, хөрөнгө оруулалт саарах төлөвтэй байна.

Асуулга 3. Нөлөөллийг саармагжуулах ерөнхий төлөвлөгөө

Дэлхий нийтээр тархаад байгаа COVID-19 вирусийг Дэлхийн Эрүүл мэндийн байгууллага цар тахал хэмээн зарласантай холбогдуулж улс орон болгон эдийн засгийн хүндрэлээс урьдчилан сэргийлэх тусгай хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж эхлээд байна. Монгол Улсын Засгийн газраас шаардлагатай арга хэмжээг шуурхай авч ажиллаж байна. Засгийн газар, Монголбанк эдийн засгаа дэмжихэд чиглэсэн төсөв, мөнгөний зөөлөн бодлого хэрэгжүүлж хөдөлмөрийн болон санхүүгийн зах зээлийг дэмжих, санхүүжилт татрахаас сэргийлэх хэрэглэгчдийн болон бизнесийн идэвх буурахаас сэргийлэх, үнийн тогтвортой байдлыг хамгаалах арга хэмжээнүүдийг авч байна.

COVID-19 вирусийн сөрөг нөлөөг сааруулах зорилгоор Монгол Улсын Засгийн газраас дараахь 3 чиглэлээр багц арга хэмжээ авахаар төлөвлөсөн. Үүнд:

1. Монгол хүний амь нас, эрүүл мэндийг эн тэргүүнд хамгаалах;
2. Иргэд, ААН-үүдээ дэмжиж, хүндрэлийг хохирол багатай даван туулах;
3. Эдийн засгаа идэвхжүүлэх, тэлэх, төсөвт зохицуулалт хийх.

Эдгээр багц арга хэмжээг хэрэгжүүлэхэд нийтдээ 5.1 их наяд төгрөг буюу 1.9 тэрбум ам.доллартай тэнцэх эх үүсвэр шаардлагатай. Үүний 1.3 тэрбум ам.доллартай тэнцэх эх үүсвэр нь гадаадын зээл, тусламжаар хэрэгжих ба үлдсэн хэсгийг нэгдсэн төсөв болон төрийн сангийн мөнгөн хөрөнгийг оновчтой удирдсанаар хэрэгжүүлнэ. Засгийн газар цаашид шаардлагатай арга хэмжээг цаг тухайд нь авах болно.

Асуулга 4. Засгийн газрын зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй өрхийн болон хувийн хэвшлийн ажлын байрыг хамгаалах, нийгмийн давхарга бүрд чиглэсэн бодлогын арга хэмжээнүүд (тооцооллын хамт)

1. Иргэн, ААН-ийг дэмжиж, хүндрэлийг хохирол багатай даван туулахад чиглэсэн дараахь багц арга хэмжээ авч байна.Үүнд:

- 1.1. Ажлын байрыг хадгалахад чиглэсэн арга хэмжээ. Үүнд:*
- Үйл ажиллагаа нь доголдсон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, иргэний НДШ-ийг 6 сарын хугацаанд тэглэнэ. Энэхүү чөлөөлөлтөд төрийн албан хаагчид, төрийн болон орон нутгийн өмчит, түүний оролцоотой, мөн гадаадын зээл, тусламж, төсвийн хөрөнгөөр ажил гүйцэтгэхээр тендерт шалгарсан ААН-ээс бусад бүх ААН-ийн ажилчид хамрагдана;
 - Жилийн 1.5 тэрбум төгрөг хүртэл борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжүүдийг 6 сарын хугацаанд орлогын татвараас чөлөөлнө. Энэхүү чөлөөлөлтөд улс, орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламжийн эх үүсвэрээр ажил гүйцэтгэхээр

тендерт шалгарч ажил гүйцэтгэсэн ААН-ийн тус орлого хамрагдахгүй. Уг арга хэмжээнд 105 мянган ААН хамрагдана;

- Бэлэн байдлын зэрэгт хамаарах хугацаанд бизнес эрхлэгчдийн төлөөгүй НДШ-д тооцох алданги, торгуулийг чөлөөлнө;
- Бэлэн байдлын зэрэгт хамаарах хугацаанд бизнес эрхлэгчдийн төлөөгүй татварт тооцох алданги, торгуулийг чөлөөлнө. Уг арга хэмжээнд нийтдээ 800,000 татвар төлөгч хамрагдах боломжтой;
- Түрээсийн төлбөрийн хэмжээгээ бууруулсан төвлөрсөн зах, худалдааны төв, үйлдвэр, үйлчилгээний газрууд болон сургууль, цэцэрлэг, хүүхэд харах үйлчилгээний зориулалтаар байр, талбай түрээслүүлдэг аж ахуйн нэгжүүдийн түрээсийн орлогод ногдуулах татварыг 2020 оны 2 дугаар сарын 01-ний өдрөөс 2020 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд чөлөөлнө;
- Төрийн байгууллагын шийдвэрээр үйл ажиллагаа нь зогссон боловч ажлын байраа хадгалсан аж ахуйн нэгжүүдийн НДШ төлдөг даатгуулагчдад ажилгүйдлийн даатгалын сангаас сар бүр 200 мянган төгрөг олгоно;
- Импортын өргөн хэрэглээний хүнсний бүтээгдэхүүний гаалийн татвар, импортын НӨАТ-ын төлөх хугацааг 2 сар хүртэл хугацаагаар хойшлуулсан. Ингэснээр импортын гол нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүний хомсдол, үнийн өсөлтөөс урьдчилан сэргийлсэн;
- Коронавирусийн тархалтын үед жижиг, дунд бизнес эрхлэгчдэд олгох зээлийг дэмжих зорилгоор барьцаа хөрөнгийн дутагдалтай аж ахуй нэгжүүдийн 300 сая төгрөг хүртэлх зээлд батлан даалт гаргана. Энэхүү арга хэмжээг 2020 оны 4 дүгээр сарын 1-нээс эхлэн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд хэрэгжүүлэх бөгөөд 108.3 тэрбум төгрөгийн санхүүжилт шаардагдахаар байна. 500 гаруй аж ахуй нэгж хамрагдахаар урьдчилсан байдлаар тооцоод байна;
- Малчдын ноолуурыг худалдан авахад зориулан Хөгжлийн банкнаас жилийн 3 хувийн хүүтэй 300 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг үйлдвэрлэгчдэд олгоно. Энэхүү арга хэмжээг 2020 оны 4 дүгээр сарын 1-ээс эхлэн 2020 оны 7 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд хэрэгжүүлэх бөгөөд 233 мянган малчин өрх, 47 гаруй аж ахуй нэгж хамрагдахаар байна;
- Хөдөө аж ахуйн салбарт үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгжүүдэд хөдөө аж ахуйг дэмжих сангаас худалдан авах тоног төхөөрөмжийн үнийг 50 хувиар хөнгөлнө. Энэхүү арга хэмжээг 2020 оны 4 дүгээр сарын 15-аас эхлэн 2020 оны 10 дугаар сарын 1-ний өдөр хүртэлх хугацаанд хэрэгжүүлснээр 1500 гаруй аж ахуй нэгжийн үйл ажиллагааг дэмжинэ.

1.2. Иргэдийн орлогыг хамгаалахад чиглэсэн арга хэмжээ.

- Иргэдийн цалингийн орлогыг 6 сарын хугацаанд орлогын албан татвараас чөлөөлнө. Энэхүү чөлөөлөлтөд төрийн албан хаагчид, төрийн болон орон нутгийн өмчит, түүний оролцоотой, мөн гадаадын зээл, тусламж, төсвийн хөрөнгөөр ажил гүйцэтгэхээр тендерт шалгарсан ААН-ээс бусад бүх ААН-ийн ажилчид хамрагдана;
- Сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг зогсоосонтой холбоотойгоор хэмнэгдсэн зардлаас 18 хүртэл насны хүүхдүүдэд мөнгөн дэмжлэг олгож, хүүхдийн мөнгийг 3 сарын хугацаанд 10 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 30 мянган төгрөг олгоно;
- Энэ оны эхний улирлын НӨАТ-ын буцаан олголтыг 2020 оны 4 дүгээр сард олгоно. Нийт 860 гаруй иргэнд 40.0 тэрбум төгрөг олгоно;

- Эрдэнэс Таван Толгой ХК-нийн ногдол ашгийг иргэд, ААН-д 2020 оны 5 дугаар сард багтаан олгоно. Нийт 2,511,332 иргэнд 119.1 тэрбум төгрөг, нийт 486 ААН-д 636.0 сая төгрөгийн ногдол ашиг олгоно;
- 2020 оны 9 дүгээр сарын 1 хүртэл цахилгааны төлбөрийг төлж амжаагүй бол цахилгааныг таслахгүй, мөн алданги тооцохгүй.

Асуулга 5. Төсвийн орлого буурч байгаагаас үүдэн зарлагын төлөвлөсөн хэмжээг бууруулах шаардлагатай ч Сангийн сайдын мэдэгдсэнээр төсвийн тодотгол хийхгүй тохиолдолд алдагдлыг хэрхэн санхүүжүүлэх, нэмэлт санхүүжилтийн эх үүсвэрийн талаар олон улсын байгууллагууд, хөгжлийн түншүүдтэй аливаа яриа хэлэлцээ хийж байгаа бол энэ талаарх мэдээлэл

Олон улсын байгууллага; хөгжлийн түншүүдтэй нэмэлт санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх чиглэлээр дараах хэлэлцээг хийж байна. Үүнд:

1. Коронавирусийн халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах, 1000 ор бэлтгэн байрлуулах зэрэг нэн шаардлагатай арга хэмжээний санхүүжилтийг Дэлхийн банкны 26.9 сая ам.долларын яаралтай тусламжийн зээлийн эх үүсвэрээр шийдвэрлэх;

2. Эрүүл мэндийн байгууллагуудын шаардлагатай тоног төхөөрөмжийн нөөцийг бүрдүүлэх арга хэмжээний санхүүжилтийг Азийн хөгжлийн банкны 30 сая ам.долларын яаралтай тусламжийн зээлийн эх үүсвэрээр шийдвэрлэх;

3. Цар тахлын голомтод ажиллаж байгаа эмнэлэг, цэрэг, цагдаагийн байгууллагуудын ажилчдад урамшуулал олгох, нэн шаардлагатай байгаа тоног төхөөрөмж худалдан авах арга хэмжээний санхүүжилтийг Азийн хөгжлийн банкны Ази, Номхон далайн гамшгийн эсрэг хариу арга хэмжээ авах сангийн 1.0 сая ам.долларын буцалтгүй тусламжийн эх үүсвэрээр шийдвэрлэх;

4. Коронавирусээс сэргийлэх, нийгмийн эрүүл мэндийн салбарын үйлчилгээ, чадавхыг бэхжүүлэх, төсвийн алдагдлыг санхүүжүүлэх чиглэлээр Азийн хөгжлийн банкны бодлогод суурилсан зээлийн хөтөлбөр (200.0 сая хүртэлх ам.доллар)-ийг хэрэгжүүлэх;

5. ОУВС-гийн Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн хүрээнд Азийн хөгжлийн банкны 60.0 сая ам.долларын төсвийн дэмжлэгийг хүлээн авах;

6. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр Европын холбооноос 47.1 сая ам.долларын буцалтгүй тусламжийн гэрээ, хэлэлцээрийг байгуулах;

7. Төлбөрийн тэнцлийн алдагдлыг нөхөхөд зориулан ОУВС-гийн Яаралтай санхүүгийн хэрэгсэл хөтөлбөрийн хүрээнд 50.0 сая хүртэлх ам.долларын санхүүжилтийн нөхцөлийг тохиролцон, шийдвэрлэх;

8. Эдийн засгийн тогтвортой байдлыг хангах үүднээс нэн тэргүүний шаардлагатай нийгэм, эдийн засгийн үр ашигтай төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх зорилгоор зээл, тусламжийн нэмэлт эх үүсвэрийг баталгаажуулах.

Асуулга 6. Арилжааны банкууд болон бусад санхүүгийн байгууллагуудын эх үүсвэрийн байдал (өртөг зардлын байдал), өөрийн хөрөнгийн дутагдлын талаарх мэдээлэл

Уг асуулгын хариуг Монголбанкнаас ирүүлсэн 2020 оны А-1/388 дугаар албан бичгээс үзнэ үү.

Асуулга 7. УИХ-аас яаралтай хэлэлцэн батлах хууль, тогтоолын төслүүд

УИХ-ын 2020 оны 4-р сарын 9-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Засгийн газраас өргөн мэдүүлсэн КОВИД-19 халдварын үед иргэдийн эрүүл мэнд, орлогыг хамгаалах, ажлын байрыг хадгалах, эдийн засгийг идэвхжүүлэх багц арга хэмжээний тухай УИХ-ын тогтоолыг баталлаа.

Мөн дээрх тогтоолтой хамт өргөн мэдүүлсэн Аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас хөнгөлөх, чөлөөлөх тухай, Татварын алданги, торгуулиас чөлөөлөх тухай, Хувь хүний орлогын албан татвараас чөлөөлөх тухай, Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай, Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай, Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай, Нийгмийн даатгалын шимтгэл төлөгчийг торгох шийтгэл, алдангиас чөлөөлөх тухай, Олон Улсын гэрээний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг хийж баталлаа.

--oo0oo--



МОНГОЛ УЛС
МОНГОЛБАНК

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Утас: 31-03-92, Факс: (976-11) 31-14-71,
<http://www.mongolbank.mn>

2020.04.01 № A-1/388
танай _____-ны № _____-т

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА
Л.ОЮУН-ЭРДЭНЭ ТАНАА

Танаас 2020 оны 3 дугаар сарын 20-ны өдөр ирүүлсэн ХЭГ/741 тоот албан бичигтэй танилцлаа.

Улсын Их Хурлын гишүүн З.Нарантуяагаас шинэ коронавирусын эдийн засагт үзүүлэх нөлөөлөл болон учрах эрсдэлийг бууруулах хүрээнд авч хэрэгжүүлж байгаа ажлын талаар Монгол Улсын Ерөнхий Сайдад тавьсан асуулга дахь Монголбанкинд хамаарах асуудлын мэдээллийг бэлтгэн хавсралтаар хүргүүлж байгааг хүлээн авна уу.

Хавсралт 24 хуудас.


Хүндэтгэсэн

ЕРӨНХИЙЛӨГЧ

Б.Д.ХАГВАСҮРЭН



14.1147



КОВИД-19 ВИРУСЫН ЭДИЙН ЗАСАГТ, БАНКНЫ САЛБАРТ ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГУЙ НӨЛӨӨ, ҮР ДАГАВАР

Ковид-19 вирусын дэгдэлт дэлхийн 200 гаруй оронд тархаж, дэлхий нийтээр 1 тэрбум гаруй хүн хөл хорионд ороод байна. Энэхүү цар тахал нь БНХАУ-ын эдийн засгийг 2020 оны эхний улиралд хумиж, дэлхийн эдийн засгийн өсөлтийг удаашруулах төлөвтэй байгаагийн зэрэгцээ манай дотоод эдийн засгийн зарим үйл ажиллагааг хумих, сааруулах нөлөөг үзүүлж эхлээд байна. Гэхдээ вирусын тархалт өдрөөс өдөрт хүрээгээ тэлэн үргэлжилж байгаа өнөөгийн нөхцөлд эдийн засагт үзүүлэх нөлөөг тоон үзүүлэлтээр хэмжихэд хүндрэлтэй бөгөөд тодорхой бус байдал өндөр байна. Тухайлбал, тодорхой бус байдал нь Ковид-19 вирусын тархалтын цар хүрээ, үргэлжлэх хугацаа, вирусын эсрэг авч хэрэгжүүлэх арга хэмжээнээс ихээхэн хамаарч байна. Иймээс энэхүү танилцуулгад Ковид-19 вирусын тархалт богино болон дунд хугацаанд үргэлжлэх тохиолдолд Монголын эдийн засагт үзүүлэх нөлөөг таамаглалт нөхцөлүүдэд үндэслэн тооцож, тоймлов.

Эдийн засгийн өсөлтөд үзүүлэх нөлөө¹


БНХАУ-ын зүгээс өвчний тархалтыг хязгаарлахаар авч буй арга хэмжээнүүд нь богино хугацаанд эдийн засгийнх нь зарим үйл ажиллагааг эрчимтэй хумиж, зарим үйлдвэрлэлийн үйл ажиллагааг зогсоох нөлөөг шууд үзүүлсэн нь манай гадаад эрэлт, экспортын үнийг бууруулах нөлөөг үзүүлж эхлээд байна. Түүнчлэн Улсын Онцгой Комиссоос авч хэрэгжүүлж буй арга хэмжээтэй холбоотойгоор уул уурхай, боловсруулах, худалдаа, тээвэр, үйлчилгээний салбарын үйлдвэрлэл буурах нөлөөг үзүүлж байна.

Ковид-19 вирусээс сэргийлэх арга хэмжээ, хязгаарлалтууд нь дотоод эдийн засгийн идэвхжилийг сулруулж, өсөлтийг сааруулж байгаа бөгөөд дотоод эдийн засагт хэрхэн нөлөөлөхийг орц, гарын хүснэгт ашиглан тооцлоо. Тооцоог хийхдээ Хувилбар 1-д вирусын тархалт 3 сард намжиж, нөлөө нь богино хугацаанд үргэлжилнэ, Хувилбар 2-д вирусын тархалт сунжирч, 6 сард намжиж, нөлөө нь дунд хугацаанд үргэлжилж, сэргэлт удаан байна гэсэн таамаглалт нөхцөлийг ашигласан болно.

Ковид-19 вирусын нөлөөг эдийн засгийн салбаруудаар задлан авч үзвэл уул уурхай, худалдаа, үйлчилгээ, тээвэр, боловсруулах салбарын нэмүү өртөг хамгийн их хэмжээгээр бууруулахаар байна. Харин корона вирусаас сэргийлэх арга хэмжээ, хязгаарлалт нь хөдөө аж ахуй, эрчим хүч, барилга, мэдээлэл холбоо зэрэг салбаруудын үйлдвэрлэлд харьцангуй бага сөрөг нөлөөтэй байхаар байна. Тооцооллын үр дүнгээс харахад эдийн засгийн өсөлт ковид-19 вирусын нөлөөгөөр 2019 оны өсөлтийн түвшин (5.1 хувийн өсөлтөөс)-ээс 2.7-оос 3.9 нэгж хувиар саарах эрсдэлтэй байна. Салбар тус бүрт үзүүлэх нөлөөг нэгтгэн зураг 1-д харуулав.

¹ Ковид-19 вирусын нөлөөллийн тооцохдоо одоогийн байгаа боломжит мэдээллүүдийг ашиглахаас гадна тодорхой таамаглалт нөхцөлүүдийг ашигласан болно. Иймд ашигласан таамаглалт нөхцөлд ашигласнаас хурдан вирусын тархалт тэлэх эсхүл хумигдах тохиолдолд төсөөлөл өөрчлөгдөх болно.


Зураг 1. Салбаруудын өсөлтөд үзүүлэх сөрөг нөлөө, 2020 он, хувиар



Эх сурвалж: Монголбанк

Ковид-19 вирусн нөлөөнөөс гадна төсвийн зардлын тэлэлт, гадаадын шууд хөрөнгө оруулалтын өсөлт, тэтгэврийн зээлийн тэглэлт зэрэг бусад дотоод, гадаад хүчин зүйлсийн нөлөөг оруулан тооцоход эдийн засгийн өсөлтийн төсөөлөл энэ онд өмнөх оноос саарахаар байна. Үүнийг 2 хувилбараар ялган тайлбарлалаа.

Зураг 2. ДНБ-ий жилийн өсөлтийн төсөөлөл



Хувилбар 1: ДНБ 2020 онд өмнөх оноос 1 нэгж хувиар буурч, 4.1 хувиар өсөх төсөөлөл гарч байна. Уул уурхайн салбарын өсөлт 2020 онд -1.0 хувьд, уул уурхайгаас бусад салбарын өсөлт 5.5 хувьд хүрэх төсөөлөлтэй. Энэ онд гадаад эрэлт, түүхий эдийн үнэ буурч, Ковид-19 вирусн нөлөөгөөр дотоод эдийн засгийн идэвхжил сулрах нь өсөлтийг бууруулах гол хүчин зүйл болж байна. Харин уул уурхайн томоохон хөрөнгө оруулалтууд үргэлжилж, төсвийн зарцуулалт өмнөх оноос тэлэх, цалингийн өсөлт болон тэтгэврийн зээлийг тэглэсэн нөлөөгөөр өрхийн хэрэглээ нэмэгдэх

нь эдийн засгийн өсөлтийг тэтгэх нөлөө үзүүлэхээр байна.

Хувилбар 2: Ковид-19 вирусн тархалт хүрээгээ тэлж, хугацаа удаашрах тохиолдолд дэлхийн эдийн засгийн өсөлт саарч, Хятадын гадаад эрэлт бууран, түүхий эдийн үнүүд буурах нь манай эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөө улам нэмэгдэх эрсдэлтэй. Мөн нөгөө талаас импортын хүнсний бүтээгдэхүүний үнэ өсч, хүнсний инфляци нэмэгдэнэ. Ийнхүү нөхцөл байдал хүндрэх тохиолдолд эдийн засгийн өсөлт өмнөх оноос 2.8 нэгж хувиар буурч, 2.3 хувь болох эрсдэлтэй байна.

Инфляцид үзүүлэх нөлөө

Инфляци өсөх эрсдэл богино хугацаанд бага боловч дунд хугацаанд нийлүүлэлтийн шалтгаантайгаар өсөх эрсдэл үүсч болзошгүй. Инфляци улсын хэмжээнд 2020 оны 2 дугаар сард 6.4 хувь, Улаанбаатар хотод 6.9 хувьд хүрсний 2.3 нэгж хувийг махны үнийн өсөлт бүрдүүлэв. Нөөцөлсөн махны хэмжээ энэ онд нэмэгдсэн, махны экспортыг хориглосон нь махны нийлүүлэлтийн хомсдол энэ хавар үүсгэхээргүй байна. Цаашид махны үнэ улирлын хандлагаа даган өөрчлөгдвөл инфляцид үзүүлэх нөлөө нь нэмэгдэхээргүй байна. Инфляцийг өдөөж байсан хатуу түлш, шатахууны үнийн өсөлтийн өмнөх оны суурь нөлөө арилж, нийлүүлэлтийн шалтгаантай инфляци буурлаа. Харин цаашид Ковид-19 вирусын эсрэг авч хэрэгжүүлж буй арга хэмжээтэй холбоотойгоор хүнсний зарим бүтээгдэхүүний импорт удаашрах тохиолдолд инфляцийн хэлбэлзэл нэмэгдэх эрсдэл үүсч болзошгүй юм. Энэ онд төсвийн төлөв тэлж, төрийн албан хаагчдын цалин нэмэгдсэн, тэтгэврийн зээл тэглэсэн зэрэг нь инфляцийг нэмэгдүүлэх хэдий ч, гадаад эрэлт буурч, дотоод эдийн засгийн идэвхжил сулран инфляцийн эрчийг бууруулах нөлөө давамгайлахаар байна. Нийлүүлэлтийн шалтгаантай огцом үнийн хэлбэлзэл үүсэхгүй гэж үзвэл, инфляци 2020 оны эхний хагаст буурч, 2-р хагаст алгуур нэмэгдэж оны эцэст 6 хувийн орчим байхаар байна.

Харин Ковид-19 вирусын тархалт удааширч, нөлөө дунд хугацаанд үргэлжлэх тохиолдолд дараах эрсдэлүүд үүсч болзошгүй. Үүнд:


- Дэлхийн зах зээл дээр хүнсний бүтээгдэхүүний үнэ өсөх, тээвэрлэлтэд саатал үүсэх, улмаар хүнсний импортын зарим бүтээгдэхүүний нийлүүлэлтийн доголдол бий болох, үнэ өсөх.
- Нийлүүлэлтийн хангамж, нөөцийн талаарх мэдээллийг тухай бүр нийтэд хүргэхгүй тохиолдолд үнэ хөөрөгдөх, ханш сулрах дарамт нэмэгдэх.
- Өнгөрсөн 2 жилийн хугацаанд БНХАУ-д гахайн ханиад гарч гахайн тоо, гахайн махны нийлүүлэлт ихээхэн буурсан энэ үед тахианы ханиад болон Ковид-19 вирус дэгдэж байгаа нь БНХАУ-д гахай, тахианы мах, далайн гаралтай бүтээгдэхүүний нийлүүлэлтийн хомсдол бий болж, бусад төрлийн махны импортын эрэлтийг өсгөж болзошгүй. Иймд Засгийн газар махны экспортын хоригийг 4-5 сард үргэлжлүүлээгүй тохиолдолд дотоодын зах зээлд хомсдол үүсч мах, махан бүтээгдэхүүний үнэ хаврын цагт огцом нэмэгдэх.
- Ковид-19 вирусын халдвар Монгол Улсад тархах тохиолдолд амны хаалт, эм, эмзүйн бүтээгдэхүүний хангамж хүрэлцээгүй болох, халдвар авсан иргэдийг эмчлэх эмнэлгийн хүчин чадал хүрэлцэхгүй нөхцөл байдал үүсэх зэрэг болно.

2008 онд дэлхийн зах зээл дээр хүнсний бүтээгдэхүүний үнэ 78 хувиар огцом өсч, зарим бүтээгдэхүүний нийлүүлэлт доголдсоноос дотоод хүнсний бүтээгдэхүүний үнийг ч мөн огцом нэмэгдүүлж байсан. Дээр дурдсан инфляцийг нэмэгдүүлж болзошгүй эрсдэлийг тоон утгаар хэмжихдээ 2008 оны хүнсний импортын бүтээгдэхүүний үнийн энэ өсөлтийн 50 хувьтай тэнцэх хэмжээгээр нэмэлт өсөлт үүснэ гэж үзсэн. Ингэж тооцоход инфляци 2020 оны эцэст хувилбар 1-ээс 2.2 нэгж хувиар өсч, 8.6 хувьд хүрэх төсөөлөл гарч байна.

Төлбөрийн тэнцэлд үзүүлэх нөлөө

Ковид-19 вирус Монгол Улсын гадаад худалдааны тэнцлийг муутгаж, төлбөрийн тэнцэлд сөрөг нөлөө үзүүлэхээр байна.

Зураг 3. Урсгал тэнцлийн төсөөлөл



Хувилбар 1 төсөөллөөр энэ онд урсгал тэнцлийн алдагдал ДНБ-ий 21 хувьтай тэнцэхээр байгаа бол, Хувилбар 2 төсөөллөөр урсгал тэнцлийн алдагдал ДНБ-ий 25 хувь болж нэмэгдэхээр байна. Төлбөрийн тэнцэл энэ онд 1.0 тэрбум ам.долларын алдагдалтай гарахаар байгаа бол уг вирусын нөлөө хүндрэх тохиолдолд 1.5 тэрбум ам.долларын алдагдалд хүрч болзошгүй байна.

Экспорт: Ковид-19 вирусын дэгдэлтээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний

хүрээнд энэ оны 2, 3-р сард БНХАУ-тай хиллэдэг боомтуудыг хааж, 40 гаруй хоногийн хугацаанд нүүрс, газрын тос, төмрийн хүдрийн экспортыг түр зогсоосон. Өмнөх жилийн тоо хэмжээ, түүхий эдийн өнөөгийн үнээр тооцоолол хийж үзэхэд хил хаагдсантай холбоотойгоор 4 сая тонн нүүрс (290 орчим сая ам.доллар), 880 мянган баррель газрын тос (27 сая ам.доллар), 590 мянган тонн төмрийн хүдэр (42 сая ам.доллар)-ийн экспорт буюу нийт 360 орчим сая ам.долларын экспортын орлого алдаад байна. 2020 оны 3-р сар гарсаар БНХАУ болон дэлхийн эдийн засгийн өсөлтийн төлөв улам муудаж, манай гадаад эрэлт, дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнүүд унаж², манай экспортын орлого буурах төлөвтэй боллоо. Вирусын тархалт дунд хугацаанд үргэлжлэх тохиолдолд дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнэ буурч, гол нэрийн түүхий эдүүдийн экспорт оны эхний хагасын туршид удааширч, экспортын орлого Хувилбар 1 төсөөллөөс 600 сая ам.доллараар нэмж буурах эрсдэлтэй байна. Цаашид Ковид-19 вирус дэлхий дахинд хэр удаан хугацаанд тархах, манай улс түүхий эдийн экспортоо хэр эрчимтэй сэргээхээс экспортын орлого хамаарна.

Импорт: Ковид-19 вирусын дэгдэлтийн улмаас Хятадын ачаа тээвэрт түр тасалдал үүссэн, мөн манай эдийн засгийн идэвхжил саарсан нөлөөгөөр импорт буурлаа. Тухайлбал, 2020 оны эхний 2 сард хэрэглээний импорт өмнөх оны мөн үеэс 12 хувиар, барилгын материал, хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт 19 хувиар буурсан голлох нөлөөгөөр нийт импорт 10 хувиар агшжээ. Ковид-19 вирусын нөлөө хүндрэх тохиолдолд эдийн засгийн өсөлт, уул уурхайн салбарын бүтээн байгуулалтыг даган хэрэглээ, шатахуун, аж үйлдвэрийн орцын импорт буурч, нийт импорт энэ онд хувилбар 1 төсөөллөөс 180 орчим сая ам.доллараар багасахаар байна.

² 2020 оны 2-р сард манай экспортын үнэ өмнөх оны мөн үеэс 7 хувиар, өмнөх сараас 8.7 хувиар буурчээ. 2020 оны 3-р сарын 24-ны байдлаар дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнэ оны эхнээс 63 хувиар, зэсийн үнэ 25 хувиар, эрчим хүчний нүүрсний үнэ 10 хувиар, төмрийн хүдрийн үнэ 4 хувиар буураад байгаа бол алтны үнэ 5 хувиар өсчээ.

Үйлчилгээ: Энэ оны 2 болон 3-р сард Ковид-19 вирус, агаарын нислэгүүд цуцлагдсантай холбоотойгоор аялал жуулчлалын үйлчилгээний орлого болон зардал оны эхний улиралд өмнөх оноос аль аль нь 70 гаруй хувиар буурч, аяллын дансны алдагдал бага зэрэг агшихаар байна. Ковид-19 вирусын нөлөө цаашид хүндрэх тохиолдолд дэлхий нийтийн аялал жуулчлалын эрэлт бууран, ирэх улирлуудад манай аялал, жуулчлалын орлого татрах, экспорт, импортын ачаа тээврийн орлого, зардал саарч, үйлчилгээний дансны алдагдал 80 сая ам.доллараар нэмэгдэхээр тооцов.


Гадаад валютын албан нөөцөд ирэх дарамт нэмэгдэхээр байна. ГВАН 2020 оны 2-р сарын эцсийн байдлаар 4.3 тэрбум ам.доллар байгаа нь Монгол Улсын 9 сарын гадаад валютын төлбөртэй импортын хэрэгцээг хангах түвшин юм. Ковид-19 вирусын тархалт богино хугацаанд үргэлжлэх нөхцөлд гадаад валютын нөөцийн өнөөгийн түвшин нь төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн богино хугацааны хэлбэлзлийг тогтворжуулахад 'хүрэлцээтэй'. Ковид-19 вирусын нөлөө удааширч үргэлжлэх тохиолдолд уул уурхайн бүтээгдэхүүний экспортын орлого огцом буурах эсвэл зогсох, валютын орж ирэх урсгал тасалдаж төгрөгийн ханш сулрах дарамт нэмэгдэх, улмаар огцом хэлбэлзэл үүсэх нөхцөл бүрдэж болзошгүй. Түүнчлэн, зах зээлд оролцогчдын ханшийн хүлээлтэд сөргөөр нөлөөлж, ашиг хонжооны сэдэлтэй нэмэлт эрэлтийг бий болгох, улмаар гадаад валютын нөөцөд нэмэлт дарамт учруулах эрсдэлтэй. Үүний зэрэгцээ, 2020 онд МУЗГ-аас Credit Suisse, Азийн хөгжлийн банк, Хятадын Эксим банкнаас авсан үндсэн төлбөр, бондуудын хүүгийн төлбөр болон томоохон ААНБ, арилжааны банкууд гадаад зээлийн төлбөр төлөх хуваарьтай байна.

Төгрөгийн гадаад валюттай харьцах ханшид үзүүлж болзошгүй нөлөө

Гадаад валютын урсгалаар өмнөх оны эхний 3 сарын байдлаар цэвэр дүнгээр 547.7 сая ам.доллар орж ирж байсан бол, 2020 оны эхний 3 сарын байдлаар цэвэр дүнгээр 20 сая ам.доллар гараад байна. Үүнд Ковид-19 вирустэй холбоотойгоор 2020 оны 2 дугаар сарын 14-ний өдрөөс нүүрсний экспортыг хязгаарласан нь томоохон нөлөө үзүүлж байна. Энэ нь ханшийн дарамтыг нэмэгдүүлж байгаа бөгөөд оны эхнээс төгрөгийн ам.доллартай харьцах ханш 1.5 хувиар сулраад байна. Энэ нь бусад валютуудтай харьцуулахад харьцангуй тогтвортой байгаа үзүүлэлт юм.

Ковид-19 вирусын тархалт эхэлснээс хойш дэлхийн 113 орны үндэсний валют нь ам.долларын эсрэг сулраад байна. 2020 оны эхнээс ам.долларын эсрэг ОХУ-ын рубль 21.9%, Бразилийн риал 22.5%, Норвегийн крон оны эхнээс 16.1% суларсан нь хамгийн муу үзүүлэлт болов. Их-10-ын бүрэлдэхүүнд багтах орнуудын валютуудын хувьд Швейцарийн франк, Японы иенээс бусад валютууд ам.долларын эсрэг сулраад байна (Зураг 4, Зураг 5).

Зураг 4. Их-10 орны валютуудын ам.доллартай харьцах ханшийн өөрчлөлт, оны эхнээс



Эх сурвалж: Блумберг

Монголбанк үндэсний мөнгөн тэмдэгт-төгрөгийн тогтвортой байдлыг хангах үндсэн зорилтын хүрээнд гадаад валютын эрэлт, нийлүүлэлтийн зөрүүнээс үүдэлтэй ханшийн богино хугацааны огцом хэлбэлзлийг бууруулах зорилгоор валютын захад шаардлагатай тухай бүр оролцон ажиллаж байна. Үүний хүрээнд 2020 оны эхний 3 сарын байдлаар нийт 736.7 сая ам.долларыг валютын захад нийлүүлж, Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайд, ЗГХЭГ-ын дарга нарын 2019 оны 01-р сарын 09-ний өдрийн 03/3/А-5 тоот хамтарсан тушаалын дагуу төрийн өмчит болон төрийн өмч давамгайлсан хуулийн этгээдээс мөн хугацаанд нийт 384.7 сая ам.долларыг худалдан авлаа.


ГВАН-ийн хэмжээ 2020 оны 2-р сарын байдлаар 4.371 тэрбум ам.долларт, хүрч, өмнөх оны мөн үеэс 20.7%-иар өсөөд байна. Энэ нь олон улсын жишиг доод түвшин болох импортын 3 сарын буюу 12 долоо хоногийн хэрэгцээг дараах байдлаар хангаж байна. Үүнд:

- Валютын төлбөртэй бараа болон үйлчилгээний импортын сүүлийн 3 сарын дундаж гүйцэтгэлээр авч үзэхэд 8.7 сарын буюу 34.8 долоо хоногийн хэрэгцээг хангах түвшинд,
- Валютын төлбөртэй барааны импортын сүүлийн 3 сарын дундаж гүйцэтгэлээр авч үзэхэд 12.4 сарын буюу 49.6 долоо хоногийн хэрэгцээг хангах түвшинд тус тус байв.

Ковид-19-ийн эдийн засагт үзүүлэх нөлөөг зөөлрүүлэх зорилгоор төв банкууд бодлогын хүүгээ бууруулж түүхэн доод түвшинд хүргэсэн нь голлох нөөцийн валютын өгөөжийг бууруулж, ГВАН-ийн өгөөжид сөргөөр нөлөөлж байна. Өгөөжийн түвшин бага, эрсдэл өндөр гадаад зах зээлийн орчинд Монгол Улсын гадаад төлбөр тооцоог тасалдахаас сэргийлэх, валютын нөөцийн аюулгүй байдлыг хангаж ГВАН-ын удирдлагын хүрээнд баталсан хязгаар (Limit), жишиг (Benchmark)-ийн дагуу төлбөр түргэн гүйцэтгэх байдал, хөрвөх чадварыг нэмэгдүүлэх, зээлийн эрсдэлийг бууруулах зорилгоор хөрөнгө оруулалтын хэрэгслийн төрөл, үргэлжлэх хугацааг багасгах буюу богино хугацаатай,

хөрвөх чадвар сайтай хөрөнгө оруулалт хийх арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллаж байна.

Зураг 5. Валютуудын ам.долларын эсрэг өөрчлөлт, оны эхнээс, хувиар



Цаашид дотоодын валютын захад үүсч болзошгүй хүндрэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, үйл ажиллагаандаа мөрдүүлэн ажиллаж байна.

Банкны салбарт үзүүлж болзошгүй нөлөө

Covid-19 цар тахалтай холбоотойгоор нийтээр мөрдөж буй хязгаарлалт, хорио цээрийн дэглэм нь зарим аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж, улмаар тухайн аж ахуйн нэгжүүд болон иргэдийн мөнгөн орлого тасалдаж, төлбөрийн чадвар муудаж, банкуудаас авсан зээлийг гэрээний дагуу төлөхөд хүндрэл үүсэж байна. Үүнтэй холбоотойгоор давхардсан тоогоор 26 мянган зээлдэгчийн 2.5 их наяд төгрөгийн зээлийн эргэн төлөлтөд доголдол үүсээд байна. Үүнээс 65.1% нь буюу 2.0 их наяд төгрөг нь аж

ахуйн нэгжид, 35.0% нь буюу 545 тэрбум төгрөг нь иргэнд тус тус хамаарч байна. Мөн хуваарийн дагуу хийгдэх ёстой нийт өрийн үйлчилгээнээс 195 тэрбум төгрөгийн үндсэн төлбөр, 72 тэрбум төгрөгийн хүү төлөгдөөгүй байна.

Иймд Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээнээс үүдэн зээлийн эргэн төлөлтөө хийхэд хүндрэл учирч буй зээлдэгчид нь зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрөө түр хугацаагаар эргүүлэн төлөх боломжгүй тохиолдолд тухайн зээлдэгчийн зээлийн ангиллыг хэвээр үлдээж, Зээлийн мэдээллийн санд ангилал бууруулж мэдээлэхгүй байх боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.

Арилжааны банкуудын зээлийн хүүний бүтэц, өөрийн хөрөнгийн мэдээлэл

Банкуудын өртөг зардлын байдлыг банкуудын хүүний бүтцээс дэлгэрэнгүй харж болно. Төгрөгийн жилийн хүү 17.5 хувиар зээлдэгчид санал болгогдож байгаагийн 16.1 хувь суурь хүү буюу зээлдэгчийн эрсдэлээс үл хамаарсан бүрдэл хэсэг байна. Нөгөө талдаа, 17.5 хувийн 11.0 хувь нь дангаар эх үүсвэрийн өртөг, харин үлдсэн 6.5 хувь нь зээл, хадгаламжийн хүүний зөрүү бүрдүүлж байна. Хүүний зөрүүнд үйл ажиллагааны зардал 1.4 нэгж хувь, зээлийн эрсдэлийн зардал 1.8 нэгж хувь, ашгийн маржин 1.5 нэгж хувийг бүрдүүлж байна (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Банкуудын зээлийн хүүний бүтэц

Эх үүсвэр	Системийн нэгтгэл	
	Төгрөг	Валют
1. Эх үүсвэрийн өртөг (%)	11.0%	4.9%
2. ЭҮ-ийн ҮАЗардал (%)	1.4%	0.9%
3. Зээлийн ҮАЗардал (%)	1.8%	0.8%
4. Бусад* (%)	0.5%	0.6%
5. Ашгийн маржин (%)	1.5%	1.4%
Зээлийн суурь хүү	16.1%	8.5%
Дундаж эрсдэлийн нэмэгдэл**	1.3%	2.7%
Харилцагчид санал болгож буй зээлийн хүү	17.5%	11.2%

Тэмдэглэгээ: *Бусад гэсэн бүлэгт аливаа урамшуулал болон бусад зардлыг оруулав; **Эрсдэлийн нэмэгдэл нь харилцагчийн зээлжих зэрэглэл, чадавхиас хамаарч өөр өөр нэмэгдэлтэй байх бөгөөд энд дунджаар авав.

Банкууд 2020 оны 3 дугаар сарын эцсийн байдлаар 5.0 их наяд төгрөгийн Төв банкны үнэт цаас эзэмшиж байгаа нь зээл гаргах хангалттай хэмжээний эх үүсвэртэй байгааг илтгэж байна.

2018 оны Активын чанарын үнэлгээгээр нэр бүхий 7 банкны хувьд нийт 573.5 тэрбум төгрөгөөр өөрийн хөрөнгөө нэмэгдүүлэх шаардлагатай гэсэн үр дүн гарсан. Банкуудын 2019 онд нэмэгдүүлсэн өөрийн хөрөнгийн тодорхой дүнг магадлан баталгаажуулах аудитын дүгнэлтээр цуцалсан. Гэхдээ зарим банкуудын өөрийн хөрөнгөө нэмэгдүүлсэн дүнг 2019 оны эцэст хоёрдогч өглөгөөр бүртгэж өөрийн хөрөнгийг нь нэмэгдүүлсэн, мөн зарим банкууд энгийн хувьцаа буюу нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгөө

нэмэгдүүлээд байна. Эдгээр өөрийн хөрөнгөө нэмэгдүүлсэн банкуудын хувьд өөрийн хөрөнгийн зохистой харьцаагаа хангаж ажиллаж байна. Харин цөөн тооны банкны хувьд өөрийн хөрөнгөө нэмэгдүүлэх шаардлага хэвээр байна.

Монголбанкнаас авч хэрэгжүүлж буй арга хэмжээ

Монголбанкнаас Ковид-19 цар тахлын банк, санхүүгийн салбарт үзүүлэх нөлөөг бууруулахад шаардлагатай боломжит арга хэмжээг бусад улс орнуудын туршлага болон банкны тухай хууль тогтоомжид нийцүүлэн хэрэгжүүлж эхлээд байна. Эдгээр арга хэмжээ нь зөвхөн мөнгөний бодлогын арга хэрэгслээр хязгаарлагдахгүй, макро-зохистой бодлого болон хяналт шалгалтын хүрээнд банкуудад мөрдүүлдэг зарим нэг шаардлага, шалгуур үзүүлэлтийг түр хугацаанд уян хатан байдлаар өөрчлөн тогтоох арга хэмжээг хамаарууллаа. Мөнгөний бодлогын хорооны 2020 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн ээлжит хурлаар бодлогын хүүг 1 нэгж хувиар бууруулж, 10 хувьд хүргэх, банкны төгрөгийн заавал байлгах нөөцийн хувь хэмжээг 2 нэгж хувиар бууруулж, 8.5 хувьд тогтоох болон бодлогын хүүний коридорыг бодлогын хүүнээс +1, -1 нэгж хувийн өргөнтэй болгон өөрчлөх шийдвэр гаргасан. Ингэснээр банкуудын санхүүжилтийн эх үүсвэрийн өртгийг бууруулах, банк хоорондын захын хүүгийн хэлбэлзлийг сааруулах, банкуудын төлбөр түргэн гүйцэтгэх чадварт дэмжлэг үзүүлэх боломж бүрдлээ. Эдгээр багц арга хэмжээний дүнд банкуудын зээлийн хүү 1 нэгж хувиар буурах, зах зээлд хамгийн багадаа 300-400 тэрбум төгрөгийн зээл шинээр гарах боломжтой гэсэн урьдчилсан тооцоо гарч байна. Түүнчлэн Ковид-19 вирусийн хурдацтай тархалтаас үүдэн дотоод эдийн засагт үүсэж болзошгүй эрсдэлээс 7 Глобал эдийн засаг, санхүүгийн зах зээлд гарч буй өөрчлөлтийн тойм сэргийлэх, банкуудын төлбөр түргэн гүйцэтгэх чадвар болон санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор Монголбанк барьцаат зээлийн журамд 2020 оны 7 сарын 31-ний өдөр хүртэл түр хугацааны өөрчлөлт орууллаа. Үүнд:

- Барьцаат зээлийн хугацааг 90 хүртэл хоног байсныг 180 хүртэл хоногийн хугацаатай болгож хугацааг уртасгав.
- Барьцаат зээлийн хүүг 16 хувь байсныг 11 хувь болгон бууруулав.
- Барьцаа хөрөнгийн жагсаалтыг тэлж, санхүүжилт авах боломжийг нэмэгдүүлэв.

Ингэснээр банкууд барьцааны нөхцөл, шаардлагыг хангаснаар Монголбанкнаас 6 сарын хугацаатай эх үүсвэрийг 11 хувийн хүүтэй авч, төлбөр түргэн гүйцэтгэх чадвараа хангах боломжийг бүрдүүлэв. Эдгээр мөнгөний бодлогын төлөвийг зөөлрүүлэх, банкны зохицуулалтыг түр хугацаанд зөөлрүүлэх, банкны төлбөрийн чадварыг дэмжихэд чиглэсэн бодлогын багц арга хэмжээ нь санхүүгийн зуучлал хэвийн үргэлжлэх боломжийг бүрдүүлээд зогсохгүй Ковид-19 цар тахлаас үүдэлтэй эдийн засагт учрах сөрөг нөлөөг бууруулахад чухал нөлөөтэй.

Банкуудад мөрдүүлж буй “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”, “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, хяналт тавих журам”-ын зарим зохицуулалтад түр хугацаанд өөрчлөлт орууллаа. Тухайлбал, зээлдэгчдийн зээлийн эргэн төлөх нөхцөлийг дахин өөрчлөх, эргэн төлөлтийн доголдолтой зээлийн ангилал, зээлийн түүхийг түр хугацаанд бууруулахгүй, дордуулахгүй байх асуудлыг бие даан шийдвэрлэх боломжийг банкуудад олгоод байна. Өөрөөр хэлбэл,

Covid-19 цар тахалтай холбоотойгоор хөл хорио тогтоосноор зээлдэгчид зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрөө түр хугацаагаар эргүүлэн төлөх боломжгүй тохиолдолд тухайн зээлдэгчийн зээлийн ангиллыг хэвээр үлдээж, Зээлийн мэдээллийн санд ангилал бууруулж мэдээлэхгүй байх боломжийг бүрдүүлж байна. Түүнчлэн, банкуудын төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааг 25 хувь байсныг 20 хувь болгож бууруулах, өөрийн хөрөнгийг хамгаалах нөөц зөрчигдөхөд авч хэрэгжүүлэх арга хэмжээг түдгэлзүүлэх шийдвэрийг гаргаснаар банкуудын санхүүгийн чадавхид эерэг нөлөө үзүүлэх боломж бүрдлээ.

Арилжааны банкууд Монголбанкнаас гаргасан багц шийдвэрийн дагуу холбогдох дотоод журам, дүрэмдээ өөрчлөлт оруулан харилцагчийн хүсэлтээр зээлийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах ажлыг эхлүүлснээр 1,069 иргэдийн 36.6 тэрбум төгрөгийн зээл, 126 байгууллагын 409.8 тэрбум төгрөгийн зээлийн эргэн төлөлтөд хөнгөлөлт үзүүлээд байна. Хэрэв зээлдэгч хорио цээрийн дэглэмтэй холбоотойгоор зээлийн үндсэн төлбөр, хүүгээ хуваарьт заасны дагуу төлж чадахгүй нөхцөл үүсэн бол өөрийн үйлчлүүлдэг банканд хандан гэрээндээ нэмэлт өөрчлөлт оруулах боломжтой юм.

Эдгээр Монголбанкнаас авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, түүний олон улсын туршлагатай нийцтэй байдлыг Ковид-19 цар тахлын үед 7 хоногийн давтамжтай Монголбанкнаас бэлтгэн олон нийтэд нээлттэй гаргаж буй 'Глобал эдийн засаг, санхүүгийн зах зээлд гарч буй өөрчлөлтийн тойм'-оос харна уу. Тус тоймын эхний 2 дугаарыг хавсаргав.

Монголбанк цар тахал хэдий хугацаанд үргэлжлэх, санхүүгийн салбар болон бодит секторт үзүүлэх нөлөөлөл хэрхэн өөрчлөгдөж байгаагаас шалтгаалан Засгийн газар, холбогдох яам, мэргэжлийн байгууллагатай хамтран бодлого, зохицуулалтын арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлэх болно.

_____ оОо _____